

УЛС НИЙГМИЙГ УДИРДАХ ХЯТАД МЕНЕЖМЕНТ БОЛ ТӨРИЙН БОДЛОГЫГ ПРАКТИКААР ШАЛГАХ ЯВДАЛ МӨН

Н.Алтанцэцэг*

Манай өмнөд хөрш БНХАУ-ын нийгэм, эдийн засгийн хөгжил дэлхий нийтийн анхаарлыг татаж байгаа нь хэн бүхэнд ойлгомжтой. БНХАУ том гүрний хувьд олон улсын харилцаа, дэлхийн бодлогод өөрийн гэсэн байр сууриа улам бүр бэхжүүлэн бататгаж байгаа нь түүний нийгэм, эдийн засгийн хөгжилтэй эрс уялдаатай.

Монгол улсын хувьд ч Хятад улс манай гадаад бодлогод чухал, тэргүүлэх байр суурийг эзэлдэг. Хөрш зэргэлдээ хоёр улс орон, Монгол улс, БНХАУ нь өнөөгийн глобалчлагдаж буй ертөнцөд харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтран хөгжих, бие биенийхээ аюулгүй байдал, тусгаар тогтнолыг хүндэтгэхээс өөр эрхэм зорилго үгүй болоод байна.

Монгол, Хятад хоёр орон хоёулаа хөгжиж байгаа орон, хоёулаа социализмын замыг туулсан орон, өнөөдөр хоёулаа зах зээлийн системд шилжин хөгжил, дэвшлийн төлөө тэмүүлж байгаа орон. Гэхдээ бидэнд Хятадын нийгэм, эдийн засгийн хөгжлийг хараад бишрээд суухаас илүү энэ орон шиг ард түмнээ өөд нь татаж, эдийн засгаа хөгжүүлэх юмсан гэдэг бодол өөрийн эрхгүй төрдөг.

Өнөөдөр монголчуудыг хятадын хүнс тэжээж, хятадын хувцас хувцаслаж, ахуй амьдралын өргөн хэрэглээний бараагаар хангаж байгаад бид талархахаас өөр яалтай нь билээ.

Одоогоос дөчөөд жилийн өмнө хоёр орон хэдийгээр Зөвлөлт маягийн замаар хөгжиж байсан ч БНХАУ өөрийн онцлогтой

социализм байгуулна хэмээн Монголын сонгосон социалист замаас хөндийрсөн. Өөрийн хүчинд тулгуурласан Хятадын онцлогтой социализм байгуулах гэж арван тав, зургаан жил туршиж, оролдсон боловч тэр нь төдийлэн амжилтанд хүрэлгүй харин ч Хятад орныг нийгэм, эдийн засаг, улс төрийн гүн хямралд оруулж байсан нь саяхан мэт санагдана.

Тэрбум гаруй хүн амтай, түүний найман зуун сая нь ядуу тариачин эзэлж байсан улс орныг нийгэм, эдийн засаг, улс төрийн хямралаас гарахад чухам юу нөлөөлөөд, яагаад энэ агуу том улс орон хөгжиж чадаж байна вэ? гэдэг нь бидний анхаарлыг зүй ёсоор татаж байгаа юм.

Хятад улс эдийн засаг, нийгмийн хөгжлийн зөв замдаа ороод 26 жилийн нүүр үзэж байна. Улс орныг хөгжлийн замд оруулахад өөрийн гэсэн бодолтой, олон сая ядуу ард түмнийхээ аж амьдралыг өөд нь татахын төлөө, ард түмэн рүүгээ чиглэсэн бодит бодлого явуулж чадсан төр, нийгмийн гарамгай зүтгэлтэн, ухаалаг, чадварлаг удирдагч Дэн Сяопины үйл ажиллагаа гол үүрэг гүйцэтгэсэн. Дэн Сяопин Хятадын нийгмийг өөрчлөн шинэчлэхийн төлөө тууштай зүтгэхдээ “өөрчлөлт, шинэчлэл бол ард түмний гэрэлт ирээдүйн төлөө хийгдэж байгаа зүйл”, “улс орон, ард түмнийг өөрчлөлт шинэчлэлт, нээлттэй бодлогын замаар хамтад нь хөгжүүлэх нь хамгаас чухал” гэсэн үзэл баримтлалыг баримталж байсан. Иймээс ч түүний хэрэгжүүлсэн “өөрчлөлт шинэчлэл,

* Н.Алтанцэцэг. МУИС-ийн ОУХС-ийн захирал, доктор (Ph.D), профессор

нээлттэй бодлого” (gaige kaifan) хөдөөнөөс тэр тусмаа тариачин өрхийн амьдралаас эхэлсэн юм.

Тухайн үед нэг тэрбум сая гаруй хүн амын 80 хувийг эзэлж байсан, туйлын ядуу амьдралтай тариачид хориодхон жилийн дотор хоолтой, хувцастай болж ахуй амьдрал нь дээшилж ирсэн нь Хятадын төрийн бодлого биелэлээ олдогийн бодит илрэл юм.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх гол арга хэмжээ бол хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нэгж, тариачдад үйлдвэрлэх эрхийг чөлөөтэй олгож, газрыг тариачдын мэдэлд өгч, айл өрхөд туслах аж ахуй эрхлэх, хамтарч хөдөлмөрлөх, хорших, худалдаа эрхлэх зэрэг эрхийг олгосон явдал юм. Айл өрх, хөдөлмөрийн хамт олныг гэрээний системд шилжүүлснээр улстай хийсэн гэрээт төлөвлөгөөг биелүүлж, илүү гарсан бүтээгдэхүүнээ зарж борлуулах эрх олгосон нь тариачдын идэвхийг эрс нэмэгдүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхийн сацуу тариачид өөрсдийгөө хоол хүнсээр хангаад зогсоогүй, нийт улс орны хэмжээнд хүнсний асуудлыг шийдвэрлэхэд гол түлхэц болсон юм.

Аливаа шийдвэрийг заавал амьдрал дээр туршиж дэлгэрүүлдэг хятад арга барилын жишгээр “үйлдвэрлэлийн хариуцлагын системийг” 1978-1979 онуудад Аньхуй, Сычуань, Юньнань, Гуандун зэрэг дөрвөн мужид нэвтрүүлэн туршиж, дараа нь бүх нутагт хэрэгжүүлсэн байна.

1978 оноос хөдөөд явуулсан өөрчлөлт шинэчлэлтийн бодлого амьдралд үр дүнтэй хэрэгжиж ирсэн нь эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлийг хот руу шилжүүлэх урам зоригийг оруулж өгсөн. 1984 оноос эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлийг хотод хэрэгжүүлэх шийдвэр гаргаж, өөрчлөлт шинэчлэлтийг албан ёсоор улс ардын аж ахуйн бүх салбарт хэрэгжүүлэх болов.

Үйлдвэрийн газрууд, ялангуяа том, дунд үйлдвэрийн газруудын үйл ажиллагааг

идэвхжүүлэх зорилт тавьсан нь хотод хийх шинэчлэлийн эхийг тавьжээ. Үйлдвэрийн газруудад өөрөө өөртөө эзэн болох эрхийг нь олгож, төрөөс өмчлөх болон удирдах эрхийг зохицуулж, үйлдвэрлэлд мөн гэрээт хариуцлагын системийг хэрэгжүүлэх болсон. Ингэснээр Хятад улсын үйлдвэрүүдийг шууд хувьчлаагүй бөгөөд төрийн болон үйлдвэрийн газруудын удирдлагын системд өөрчлөлт оруулж зохицуулалт хийж эхэлсэн.

Үйлдвэр, аж ахуйн газрын удирдлагын менежментийг макро төвшинд зохицуулах, өөрөөр хэлбэл төлөвлөлтийн систем, үнийн систем, санхүүгийн систем, мөнгөний эргэлтийн системд өөрчлөлт хийх явдалтай уялдуулах шаардлага тулгарсан. 80-аад оны дунд үеэс үйлдвэр, аж ахуйн газруудыг төлөвлөгөөнд хэт баригдах явдлаас чөлөөлөх, үнийг харьцангуй чөлөөлөх, банкны системд харилцааны болон зээл олгох үйл ажиллагаа нэвтрүүлэх зэргээр өөрчлөлт хийж “эдийн засгийн хөндлөн холбоонд” зохицуулалт хийсэн. Эдгээр арга хэмжээний үр дүнд 80-аад оны сүүлч гэхэд үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж ирсэн.

Энэ том орны эдийн засгийн өөрчлөлт, тийм ч дардан замаар яваагүй. 1988 он гэхэд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэт үйлдвэрлэл явагдаж, “эдийн засаг халууралд орж” инфляци нүүрлэж ирсэн. Улс орныг инфляциас аврах удаа дараагийн арга хэмжээ авч 1994 онд хямрлаас зөөлөн газардах (guan zhe lu) бодлого явуулсан.

Эдийн засгийн инфляцийг бууруулах нөхцөлд эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах, гадаад валютын нөөцийн өсөлтийг хамгаалахад гол анхаарлаа хандуулж байв.

Ихэнхи орнууд инфляцид өртөхдөө эдийн засгийн өсөлтийг удаашруулах буюу зогсоох, тэр ч байтугай хямралд ордог. Гэтэл Хятад улс инфляцийн төвшинг бууруулах алхам хийхдээ эдийн засгийн өсөлтийг их хэмжээгээр бууруулаагүй бөгөөд үнийн өсөлтийг ч хязгаарлаж чаджээ.

Хятадын эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн нэгэн хүчин зүйл бол эдийн засгийн нээлттэй бодлого. Энэ бодлогыг хэрэгжүүлэхдээ эхлээд зүүн өмнөд Азид буй баян чинээлэг хятадуудын хөрөнгийг татах бодлого явуулав. Дэн Сяопин 1979 оны 1 дүгээр сарын 17-нд бизнесмэнүүдтэй хийсэн уулзалтанд хэлэхдээ: “Бид гадаадын техник, технологи, хөрөнгийг оруулахдаа цагаач иргэд, цагаач ажил хэрэгч хүмүүсийг татан оролцуулж үйлдвэрлэл явуулж болох юм” гэж байв.

Иймээс нээлттэй бодлого явуулахдаа эхлээд далайн эргийн мужуудад, тухайлбал Гуандун, Фузянь хоёр мужид эдийн засгийн нээлттэй бүс байгуулахаа зарласан. Энэ хоёр мужийн Шэньжэн, Жухай, Шаньтоу, Сямэн зэрэг дөрвөн бүсийг онцгой бүс болгон гадны хөрөнгө оруулалт, менежментийг хятадын нөхцөлд туршин үзэж, үр дүнд хүрсний дараа бусад газар, бүс нутагт нээлттэй бүс, хот, район бий болгосон.

1990 он гэхэд эдийн засгийн онцгой бүс Гуанжоу, Шэньжэн, Жухай, Фушан, Жуньшан зэрэг хотын хүмүүсийн дундаж орлого 800 ам долларт хүрч ирсэн. 1992 онд Дэн Сяопин 88 насандаа Шэньжэн, Жухай эдийн засгийн хоёр онцгой бүсээр явахдаа: “Шэньжэнь, Жухай болон бусад эдийн засгийн онцгой бүс маш хурдтай хөгжиж байна. Ийм хурдан хөгжинө гэж бодоогүй. Үүнийг үзэж харсаны дараа итгэл

найдвар улам их боллоо” хэмээн урамшиж, “нээлттэй бодлогыг улам өргөн хүрээгээр явуулах хэрэгтэй, одоогийн нээлттэй бодлого дутуу байна. Хятад маш том зах зээлийн орон. Олон орон бидэнтэй хамтран ажиллах хүсэлтэй байгаа, наймаа худалдаа хийх сонирхолтой байгаа. Энэ бол бидэнд ашигтай. Энэ бол манай стратеги” хэмээн нээлттэй бодлогыг цаашид гүнзгийрүүлэн хэрэгжүүлэхийг захисан байдаг.

Иймээс ч дараа дараагийн Хятадын удирдлага Зян Зэминь, Ху Жиньтао нар нээлттэй бодлогыг Хятадын зүүн өмнөд зүгээс төвийн бүс нутагт, төвөөс баруун бүс нутагт хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Хятад улс төрийн бодлогын залгамж, нэгдмэл чанарыг эрхэмлэдэг. Иймээс ч Мао Зэдун, Дэн Сяопин, Зян Зэмений захиасыг Ху Жиньтао боловсронгуй болгож үргэлжлүүлэн хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

Өнөөгийн Хятад орон хооллох, хувцаслах, үйлдвэрлэх асуудлыг үндсэнд нь шийдсэн байна. Харин одоо Хятадын нийгмийн өмнө тавигдаж байгаа гол том зорилт бол боловсрол, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжлийн төвшинг дээшлүүлж, дэлхийд манлайлах үүрэг бүхий хүчирхэг гүрэн болоход оршиж байна.

Хятад улс энэ зорилтдоо хүрч чадахын баталгаа нь төрийн бодлогын оновчтой эсэхийг практикаар шалгаж, хэрэгжилтээр нь үнэлдэг явдал юм.